УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Аймгийн ИТХ нь өөрийн гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, баталсан хөтөлбөр, зорилтынхоо хэрэгжилтэд хяналт тавьж боловсронгуй болгох, аймгийн ИТХ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн журмуудаа батлах, Хурлын хороо байгуулж, Хороод нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Мөн аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 2016-2020 оны үндсэн чиглэл, мөрдөх журмууд, төлөөлөшчийн ёс зүйн дүрэм, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны зорилт, аймгийн 2017 оны төсөв, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлалаа.

Нэг. Зохион байгуулсан ажил, үйл ажиллагааны үр дүн


Давсны хэрэглээг бууруулах хөтөлбөр, Монгол улсын Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Увс аймагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцээд 94,6% биелэгдсэн гэж дүгнэлээ.

“Эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай” 2014 оны А/159 тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаар ЭМГ-ын даргын мэдээллийг хэлэлцээд удаашралтай байгаа, бага хувьтай хэрэгжиж байгаа заалтуудыг хэрэгжүүлэх талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллахыг ЭМГ-ын дарга, НХХ-ийн дарга нарт,

“Нийгмийн халамж, үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 2013 оны А/78 тогтоолын хэрэгжилтийн тайланг хэлэлцээд нийгмийн халамж үйлчилгээг авах зорилтот бүлэгт ОНХС-аас хөрөнгө дайчлах,ахмадын шинэ сувилалыг ашиглалтанд оруулахыг холбогдох хүмүүст үүрэг болголоо.


Ан агнуурын 2016-2020 оны менежментийн төлөвлөгөө, аймгийн Ахлах сургуулийн хөгжлийн хөтөлбөр, соёл урлагийн салбарыг 2016-2021 онд хөгжүүлэх хөтөлбөрийг батлаж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журамд 2 удаа өөрчлөлт оруулаа.

Төрийн байгууллагын удирдлага, мэдээллийн цогц систем/ able/-ийн ашиглалтыг сайжруулж төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа бүрэн ашиглах тухай тогтоол гаргалаа.



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 тоот тогтоол, Аймгийн засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/481 дүгээр захирамжийн дагуу “Орон нутгийн өмчийн газар” байгуулагдсанаар хурлын ажлын албаны өмчийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд ЗДТГ-т шилжин ажилласан ба ИТХ-ын ажлын албаны бүтцийг шинэчиллээ.

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулж, 2-р хуралдаанаар Хурлын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэж, Хурлын үйл ажиллагаанд мөрдөх Хурлын хуралдааны байнгын дэг, аймгийн ИТХ-д асуудал санаачлан өргөн мэдүүлэх, хуралдааны бэлтгэл хангах журам, Төлөөлөгчид, тэргүүлэгчдийн ажиллах журам, Хороод, намын бүлэг ажиллах журам,Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн хяналт, хоригийг хүлээн авч шийдвэрлэх журам, аймгийн ИТХ-аас аймгийн Засаг дарга, ЗДТГ, бусад байгууллага, иргэдтэй харилцах, хамтран ажиллах журам, төлөөлөгчдийн ёс зүйн дүрмийг хэлэлцэн баталж гарын авлага болгон хэвлэж төлөөлөгчдөд болон сумын ИТХ-д хүргүүллээ.



УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2 сургагч багш бэлтгэж, аймаг сумдын нийт 444 төлөөлөгчдөөс 400 төлөөлөгчийг сургалтад хамруулаа.





Монгол Улсын бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн портал ХУРАЛ.МН цахим сайтыг хөтлөх, хөгжүүлэх админы сургалтад хурлын нарийн бичгийн дарга, мэргэжилтэн нарыг хамруулаа. Ингэснээр бүх шатны хурлын байгууллагын цахим хуудас жигд хөгжиж, олон нийтэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэх боломж бүрдлээ.

Авилгын эсрэг Үндэсний хөтөлбөр хэрэгжих болсонтой холбогдуулан АТГ-аас аймагт ажлын хэсэг ажиллах үеэр Зүүнговь, Өлгий, Өмнөговь, Түргэн, Малчин, Наранбулаг сумдын ИТХ-ын төлөөлөгчдийг сургалтад хамруулаа.

Аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид ХБНГУ-ын Фридих Эбертийн сангаас зохион байгуулсан “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал”, Аймаг болон Улаангом сумын хурлын төлөөлөгчдийг Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ГОУХАН/-ийн хэрэгжүүлж буй “Эрчим хүчний үр ашиг” төслөөс “Ашиглалтын хугацааны зардал тооцох аргачлал” сургалтад хамруулаа.

Ойрад Монголд бурхан шашин дэлгэрсний 400 жилийн ойд зориулан “Баруун Монголын шашин соёл” эрдэм шинжилгээний 2-р хурлыг Увс аймгийн ИТХ, Дэчинравжайлин хийд, Ховд аймгийн Ганданпунцагчойлин хийд, Түүх соёл, хэл бичиг судлалын “Тод номын гэрэл” төв хамтран зохион байгууллаа.

Сумдын ИТХ-ыг сонгох 2016 оны сонгуулиар Хяргас, Сагил, Завхан, Тариалан сумуудад нэр дэвшигчдийн санал тэнцэж дахин сонгууль явагдаж дууслаа. Ингэснээр 19 сумын хурлын дарга сонгогдож ажлаа эхлүүлэн УИХ-ын тамгын газрын 2016 оны 10 сарын 27-ны өдрийн 15/629 тоотын дагуу МУ-ын шинэ үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулан УИХ-ын дарга дарга М.Энхболдын ивээл дор зохион байгуулагдаж буй шатар сонирхогчдын насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний 1-р шатыг амжилттай зохион байгууллаа.

ОХУ-ын Тува улсын Дээд хурал, Увс аймгийн ИТХ-ын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Орос хэлний уралдааныг ЕБС-ийн 8 ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгууллаа.



ОХУ-ын Тува улсын Дээд хурлын хамтын ажиллагааг улам бэхжүүлэн ажиллаж Тува улсын хурлын ажлын албаны мэргэжилтнүүд ирж харилцан туршлага солилцож цаашид хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурах, найрсаг уулзалтуудыг тогтмол зохион байгуулахаар төлөвлөө гарган ажиллаж байна.

Аймгийн ИТХ нь 2016 онд 70 ажил арга хэмжээг төлөвлөснөөс 64 ажил арга хэмжээг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэн зохион байгуулж, 1 ажил хойшлогдож, 5 ажил тасарч 91,4%-ын биелэлттэй байна.

<u>Хурлын төсвийн зарцуулалт:</u>

Аймгийн ИТХурал, ажлын алба 2016 онд 11 орон тоотойгоор 312.9 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байгаагийн 36.7% нь ажлын албаны ажилчдын цалин урамшуулалд, 4.2% НДШимтгэлд, 4.3% нь дотоод болон гадаад томилолтод, 15.3% нь тээвэр шатахууны зардалд, 1.6% нь бичиг хэрэгт, 1.8% нь шуудан холбоонд, 1.4 бага үнэтэй түргэн элэгдэх зардалд, 6.7% нь хуралдааны зардалд, 0.6% нь намын суудалд 3.8% нь мэдээлэл сурталчилгаанд, 7.9% нь нэг удаагийн зардалд, 7.7% нь ГХУСАЗЗөвлөлийн зардал, 1% нь цагаатгалын комиссын ажилд, 1,1% нь эд хогшил худалдан авахад, 4.4% урсгал засварын зардалд, 5.8% нь бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардалд, тус бүр зарцуулагдахаар төсөвлөж одоогийн байдлаар 290.6 сая нь үйл ажиллагааны дагуу зарцуулагдсан байна.

Нэмэлт санхүүжилтээр “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслөөр 60 сая төгрөгийн санхүүжилт бүхий сургалт зохион байгуулсан.

<u>Сумдын ИТХ-ын ажлын талаар:</u>

Аймгийн 19 сумдын ИТХ-ын хуралдаан 41 удаа хуралдаж 235 асуудал хэлэлцэж 788 заалт бүхий 240 тогтоол гаргаж, 14 дэд хөтөлбөр, төлөвлөгөө баталсан байна.

Тэргүүлэгчдийн хурал 230 удаа хуралдаж, 824 асуудал хэлэлцэж 1970 заалт бүхий 823 тогтоол, 15 журам гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Хурлын хороод 50 удаа хуралдаж, 46 санал дүгнэлт гаргаж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажил, үйлчилгээ, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт зэрэгт 244 удаа хяналт шалгалт хийж 596 хүн хамрагдаж 25 зөвлөмж өгч ажилласан байна.

Багийн ИНХ бүр 1-2 удаа буюу 248 удаа хуралдаж 9337 иргэн оролцож 171 асуудал хэлэлцэж Иргэдийн дунд 129 хэлэлцүүлэг, 40 санал асуулга явуулж 5188 иргэн оролцож 845 санал гаргаснаас 544 саналыг захирамж, тогтоол, тушаалд тусгаж 171 саналыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилжээ.

2016 оны ажлын дүнг үндэслэж аймгийн ИТХ-ын шилдэг төлөөлөгчөөр Э.Баатарсан,Е.Баяраа, О.Ганцоож, сумын ИТХ-ын нарийн бичгийн 3 даргыг тус тус шалгаруулж аймгийн ИТХ-ын Хүндэт медальон, дурсгалын зүйлээр шагнан урамшууллаа.

Орон нутгийн өмчийн талаар:

Орон нутгийн өмчийн 153,1 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, 281,931 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 1,671 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 64,8 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 26 тогтоол, 2 тэмдэглэл гаргаж байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн асуудлуудыг хууль журмын дагуу бүрэн шийдвэрлүүлж, 94% биелэлттэй байна.

Орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 11сая, орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулсны 125 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй ажилласнаас 135 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 108%-иар давуулан биелүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Увс нуурын дэргэдэх "Аялал жуулчлалын гэр бааз"-ын үйл ажиллагааг менежментийн гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих ажлын хэсгийн тайланг хэлэлцээд "Морьтны өргөө" ХХК-ийн менежментийн гэрээний биелэлт 74,5% "Хангалттай" гэж дүгнэсэн.

Орон нутгийн өмчит 187 хуулийн этгээдийн 214, 3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө орон нутгийн өмчид бүртгэлтэй байна.

2016 оны аймаг, сумын ИТХ-ын онцлог шинэ ажлаар ширээний календарь аймгийн ИТХ-ын 2012-2016 оны ажлын тайлан, баталсан хөтөлбөр, журмыг ном болгон хэвлүүлж, бичмэл сэтгүүлийн 3 дугаар, онцлох мэдээний 10 дугаар тус тус бэлтгэн гаргаж аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ, бусад холбогдох байгууллагуудад хүргүүлж мэдээллээр хангаж ажиллалаа.

Орон нутгийн МВС, САМА телевизүүд, "Увсын өнгө" сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулан аймгийн ИТХ-ын хийж хэрэгжүүлсэн ажлаа цаг тухайд нь иргэдэд мэдээлэн сурталчилж ажиллалаа.

"Төлөөлөгчийн цаг" Телевизийн нэвтрүүлэг, цахим ярилцлагыг нийт төлөөлөгчдийн дунд тогтмол явуулах удирдамж боловсруулан баталж төлөөлөгч бүрийг нэвтрүүлэгт оролцуулахаар төлөвлөн үйл ажиллагааг нь эхлүүлж өлөөлөгч О.Ганцоож орон нутгийн МВС телевизээр нэвтрүүлэгт оролцож, Мөн Тэргүүлэгч С.Анхбаяр цахим сайтаар дамжуулан ярилцлага өгч тойргийн сонгогчдын дуу хоолой нь болсоор байна.

Улаангом сумын 1-р багаас сонгогдсон төлөөлөгч, Тэргүүлэгч Е.Баяраа нь тойргийнхоо тулгамдсан асуудлын нэг болон Чандманы автобусны буудлыг 5,5 сая төгрөгөөр барьж, амьдралын боломж муутай хүүхдүүдэд сургуулийн дүрэмт хувцас гардуулж, ЕБС-ын хүүхдүүдэд хичээл сургалтын материал болон спортын багт жигд хувцас хандивлаж, Улаанбаатар хотод суралцаж буй 1-р багийн харьяат оюутан залуучуудын дундах спортын тэмцээнийг амжилттай зохион байгуулав.

Улаангом сумын 11-р багаас сонгогдсон төлөөлөгч, Тэргүүлэгч С.Анхбаяр нь "Шинэ Улаангом" буюу Битүү захын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хувьд захын 12000 төгрөгний түрээсийн төлбөрийг 10.000 болгож бууруулаа. Мөн зун усны үерт автсан айл өрхүүдийн хашаанд ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг шуурхай зохион байгууллаа.

Өлгий сумаас сонгогдсон төлөөлөгч Т.Амарзаяа нь баруун аймгуудад гарч буй бог малын "мялзан" өвчин гарсантай холбогдуулан тойрогтоо 3 удаа явж ажиллаж өвчлөлийн голомт бүхий айл өрхүүдэд нэг удаагийн хувцас 60ш, амны хаалт, бээлий, ариутгалын бодис, хуурай нойтон салфетка зэрэг гарын доорх эм, хэрэгслүүдийг өөрийн зардлаар олгож, нарийн мэргэжлийн 6 эмч бүхий баг бүрдүүлэн 700 гаруй хүнд эмнэлгийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Улаангом сумын 4-р багаас сонгогдсон төлөөлөгч, Тэргүүлэгч Д.Мягмарсүрэн амьдралын боломж муу нэр бүхий 26 оюутны өргөдөл, хүсэлтийн дагуу 2.150.000 төгрөгний замын зардлын дэмжлэг үзүүлж, Улаангом сумын 7-р багаас сонгогдсон төлөөлөгч О.Ганцоож Япон улсын Ротари байгууллагатай хамтран "Эх дэлхийгээ мэдье" уриатай арга хэмжээг Улаангом сумын ЕБСургуулиудын дунд зохион байгууллаа.

Хоёр. Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаан

Аймгийн ИТХ-ын хуралдаан 5 удаа 91,7%-ийн ирцтэй хуралдаж 16 асуудал хэлэлцэж 86 заалттай 24 тогтоол баталж, 2 тэмдэглэл гаргалаа. Давхардсан тоогоор 150 төлөөлөгч санал шүүмжлэл гаргаснаас 68 санал хурлын шийдвэрт тусгаж, 80 санал шүүмжлэлүүдийг Аймгийн болон Улаангом сумын Засаг дарга, Боловсрол соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, ГХБХБГ, Нэгдсэн эмнэлэг, **зэрэг холбогдох байгууллагуудын зорилт, ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүллээ.**

Аймгийн ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн 11-р хуралдаан: 2016 оны 5-р сарын 20-нд хуралдаж аймгийн 2016 оны төсвийн тодотгол, газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, концессаар гүйцэтгэх ажлын тухай, Улаангом сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлуудыг хэлэлцэн Улаангом сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дахин хэлэлцэхээр буцааж, бусад асуудлыг хэлэлцсэн.

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаан: 2016 оны 7-р сарын 14-нд хуралдаж аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн дүнг хэлэлцэж 41 төлөөлөгчөөс 40 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрч, аймгийн ИТХ-ын даргаар Э.Насанбатыг болон 11 тэргүүлэгчдийг сонгож, аймгийн Засаг даргад Д.Батсайханы нэрийг дэвшүүлж Ерөнхий сайдад уламжиллаа. Өмнөговь сумын 1тойргийн сонгууль маргаантай байсан учраас төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх асуудлыг түр хойшлуулсан.

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдаан: 2016 оны 10-р сарын 18-нд хуралдаж аймгийн 2016 оны төсвийн тодотгол, Хурлын үйл ажиллагааны үндсэн журмуудад өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталлаа.

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 3-р хуралдаан: 2016 оны 12-р сарын 1,2-нд хуралдаж аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны зорилт, аймгийн 2017 оны төсөв, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймгийн 2015 оны төсвийн гүйцэтгэл, аймгийн 2017 оны төсвийг баталаа.

Аймгийн ИТХ-ын 2016 оны ажлын үр дүн, цаашдын зорилтын тухай хэлэлцээд аймгийн ИТХ-ыг "Хангалттай " ажилласан гэж дүгнэлээ.

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 4-р хуралдаан: 2016 оны 12-р сарын 21-нд хуралдаж Өмнөговь сумын 10-р тойргийн сонгуулийн маргаан дууссан учраас

төлөөлөгч Г.Нямбаярын бүрэн эрхийг зөвшөөрч, аймгийн Засаг даргад Д.Батсайханы нэрийг дахин дэвшүүлж Ерөнхий сайдад уламжиллаа

Уг хуралдаануудаар гарсан 80 санал шүүмжлэлийг болон холбогдох бусад байгууллагуудад багцлан хүргүүлж, хэрэгжилтийг нь холбогдох байгууллага, албан тушаалтан зохион байгуулж, хурлын ажлын албаны зүгээс биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

***Гурав. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан*:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 18 удаа хуралдаж 91 асуудал хэлэлцэж 190 заалт бүхий 79 тогтоол, 20 тэмдэглэл гаргаж, ой тэмдэглэх, орон нутгийн өмчийн тооллогод үнэлгээ өгөх, ГХУСАЗЗөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэх, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын (ОНӨААТҮГ) үйл ажиллагаанд хяналт хийх зэрэг ажлын хэсгүүдийг байгуулж, цаг үе, өвөлжилтийн бэлтгэл хангах, өвс тэжээлийн нөөц бэлтгэх зэрэг тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж үр дүнг нь тооцоод байна.

Дээрх тогтоолуудын хэрэгжилтийг хангах зорилгоор хурлын даргын захирамж-15, ажлын албаны даргын тушаал 8-ийг гаргаснаас гадна 2016 онд Засгийн газрын тоот 15, тогтоол 11, ЗГ-ын тэмдэглэл 6, ЗГ-ын захирамж 2, УИХ-ын албан тоот 9, сум байгууллага, агентлаг, хэлтэс төрийн бус байгууллагын албан тоот 132, Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан тоот 3, Авилгатай тэмцэх газрын тоот 12, Сонгуулийн ерөнхий хорооны албан тоот 28, ЦАУЗБУКомиссын албан тоот 9, Засаг дарга, ЗДТГ-ын тэмдэглэл 12, сумын хурлаас 38, Сумын сонгуулийн хорооноос 19, Цагдаагийн хэлтэс 17, Аудитын тайлан 14 албан тоот 5, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс 8, ГХУСАЗЗ-ийн гишүүн байгууллагаас 24, иргэдийн өргөдөл гомдол 21, НӨУБайгууллагаас 6, нийт 391 албан тоот хүлээн авч судлан шийдвэрлэлээ.

Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцээд Гавьяат цолоор 8, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 6, Цэргийн гавьяаны одонгоор 2, “Алтан гадас” одонгоор 15, Хөдөлмөрийн хүндэт медалиар 16 нийт 47 хүнийг шагнуулахаар Ерөнхийлөгчид уламжилж, холбогдох материалуудыг Тамгын газарт нь хүргүүлснээс хүн шагнагдаад байна.





Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал нийт 16 удаа хуралдаж 83 асуудал хэлэлцэж, 202 заалт бүхий 75 тогтоол, 23 тэмдэглэл гаргаж, төлөвлөгөөт биелэлт 96 хувьтай байна.

, Согтууруулах ундаа түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэх, зэрэг асуудлыг хэлэлцэн баталлаа.

Хорооны өжил:

Аймгийн 7 дахь удаагийн сонгуулийн 2-р хуралдаанаар Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хороог 15, Төсөв, санхүү эдийн засгийн хөгжлийн хороог 21, Хууль эрх зүй, дотоод хяналтын хороог 12, Хүний хөгжил, нийгмийн асуудлыг хороог 17, Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хороог 16 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Хурлын хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тусгай удирдамж боловсруулан нутгийн өөрөө удирдах байгууллагаас гарсан тогтоол, шийдвэр, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэх, өвөлжилтийн бэлтгэл хангалт, тулгамдаж буй асуудлыг судлах, төрийн албан хаагчдын санал хүсэлтийг нь сонсох зорилгоор Хүний хөгжил, нийгмийн асуудлын хороо Улаангом сумын ЗДТГ, эрүүл мэндийн төвүүд, сургууль, цэцэрлэгүүд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, музей, номын сан, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, дулааны станц зэрэг 20 гаруй төрийн байгууллагуудаар 3 хэсэгт хуваагдан явж ажиллалаа. Уг ажлын үр дүнг хэлэлцэж аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад албан тоот, ажлын чиглэлүүдийг хүргүүлээд байна.

Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хороо 2016 оны 11-р сарын 04-ны өдөр хуралдаж “Гулзат орон нутгийн тусгай хамгаалалттай газрын өргөтгөлийн тухай” асуудлыг хэлэлцэж тэргүүлэгчдийн хурлаар оруулж аймгийн ИТХ-ын 3-р хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Аймгийн ИТХ-ын хороод 13 удаа хуралдаж 14 санал дүгнэлт гаргаж ажилласан байна.

Дөрөв. Хяналт шалгалтын ажил

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Үндэсний аудитын харьяа Увс аймгийн аудитын газраар

1. “Увс аймагт хийгдсэн ойжуулалт, хэрэглээний болон түлшний мод, ховор нэн
2.

-д нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийлгэлээ.

Тав. Бусад ажил

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 08 сарын 03 өдрийн А/82 тоот тогтоолоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн (ГХУСАЗЗ) бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа.

ГХУСАЗСЗөвлөл нь холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн ажлын үр дүнг хэлэлцэх хурлыг 2 удаа зохион байгуулж, анхаарах асуудлынхаа талаар дараа улирлын хийх ажлынхаа хуваарьт тусгаж хэрэгжүүлж ажиллалаа. Цагдаагийн газар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас “Гэр бүлийн хүчирхийлэлгүй амар тайван амьдарцгаая”, “Мал сүргээ гэмт халдлагаас хамгаалья” 2 төрлийн зурагт хуудас, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах соёлыг хамтдаа бий болгоё” гарын авлага зэрэг 4 төрлийн зурагт хуудас, гарын авлагыг 8000 хувь хэвлүүлэн иргэд олон нийтэд тараан ажиллаж байна.



Малчин сумын Хүн эмнэлэгийн үйлчилгээнд явж байсан УАЗ-469 маркийн машиныг блансаас блансад шилжүүлж цагдааг унаажуулах арга хэмжээг авч ажиллажээ.

Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр:




Бөхмөрөн сум орох, гарах хаалга дээр 500.000 төгрөгөөр хийгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх самбар

Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр гарын авлага, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль, журам сурталчилах чиглэлийн нугалбар хуудасыг 19 сумын хэмжээнд 1710 ширхэг хийж хэвлүүлэн айл өрхөд хүргэж 11 хууль, 2 журмыг 19 сумын нийт 7995 иргэн, сумдын хилийн заставын хугацаат болон гэрээт цэргийн 640 гаруй албан хаагчид сургалт хийсэн.



Зөвлөмжийн мөрөөр гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэд олон нийтэд мэдээллийн хэрэгсэл, гарын авлага, шторк, кейс, зурагт хуудас хэлбэрээр хууль сурталчлах сургалт сурталчилгааны ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажилласан .





Үүнд хэвлэн бэлтгэсэн доорх тараах материалд тулгуурлан нарийвчилсан хуулийг таниулан сурталчлах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах

салбар зөвлөлөөс санаачлан “Мал хулгайлах гэмт хэрэг”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” – ээс урьдчилан сэргийлэх, дээрх гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор үе шаттайгаар зурагт хуудас, плакат, нугалбар хэвлүүлэн Увс аймгийн 19 сумын ИТХ, 92 багийн иргэдийн нийтийн хурлаар дамжуулан 5500 иргэнд хүрсэн сургалт, сурталчилгаа хийлээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сэрэмжлүүлгийг сэрэмжлүүлгийг мэдээллийн самбарт тухай бүр байршуулан иргэдэд түргэн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.





Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/150 тоот тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид Цагдаагийн газар, МХГ, СХЗХ, Татварын хэлтсээс хяналт, шалгалтыг хийж 9 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцалсан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд техникийн дэвшлийг бүтээлчээр ашиглах, гэмт хэрэг илрүүлэлтийг шуурхай болгох, таслан зогсоох, бартаа саадтай газрыг богино хугацаанд тогтоох ач холбогдол бүхий “Нисдэг камер”-ийн төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж, мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн сурталчлах урсдаг дэлгэц бүхий “Электрон самбар”, гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл хүлээн авч хурдан шуурхай шийдвэрлэх зорилготой 1800-1505 тусгай дугаарыг нээн ажиллуулж байна.

320 гаруй байгууллага, аж ахуйн нэгж камержуулагдаж байгууллагуудын гадна, дотно орчныг хянах гэмт хэрэг гарах нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх, аливаа хэрэг, зөрчлийг хурдан шуурхай илрүүлэхэд ач холбогдолтой үр нөлөөтэй ажил болсоор байна.

Мөн Өндөрхангай, Зүүнхангай, Малчин, Тариалан, Давст, Хяргас сумын ГХУСАЗСЗ, худалдаа үйлчилгээний цэгийн эзэдтэй хамтран сумын төв хэсгээ бүрэн камержуулаад байна.

Улаангом сумын төв замын уулзвар гарцуудад 25 цэгт 75 камер суурилуулан гэмт хэрэг, зөрчил илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд ашиглан ажиллаж байна.





Камерын хяналтаар гэмт хэргийн шинжтэй 13, захиргааны зөрчлийн шинжтэй-11, иргэдээс эд зүйлээ таксинд орхисон, гээсэн гэх 14, Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" зөрчсөн 482 зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтанд танилцуулсан. Үүнээс 269 зөрчилд 2 596 800 төгрөгний торгууль оногдуулан 213 зөрчлийг Замын цагдаагийн тасгийн алба хаагчдад шилжүүлж өгч ажилласан байна.

Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой урьдчилан сэргийлэх чиглэлийн бэлтгэл ажлуудыг шуурхай авч хэрэгжүүлсний үр дүнд иргэд, сонгогчдын амгалан тайван байдлыг хангуулан ажиллалаа.

Хариуцсан хэсгээр дотоодоос 7 удаагийн 88 толгой адуу хил дамнан хулгайлагдсанаас 3 удаагийн 39 толгой адууг хил дээр саатуулж, 4 удаагийн 17 толгой адууг хамтарсан эрлээр олж, малын эздэд нь хүлээлгэн өгч тус тус шийдвэрлэсэн.

Сургуулийн өмнөх насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн цэцэрлэгүүдийн дунд "ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ-2016", ерөнхий боловсролын сургуулиудын дунд "НОГООН ГЭРЭЛ ЦАГААН ШУГАМ-2016 тэмцээнийг зохион байгууллаа.





Мөн аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд багачуудад замын хөдөлгөөнд оролцох зөв дадал, мэдлэг, хандлага төлөвшүүлэх зорилгоор School Police арга хэмжээг улирал бүр зохион байгуулж хүүхдүүдийг зам хөндлөн гарах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлгөөнд оролцсон жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг мөрдөх дадалд хэвшүүлэх үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллалаа.



Авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2016 онд аймаг, сумын ИТХ-ын нийт 532 сонгуультан, албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгийг цаг хугацаанд нь гаргуулан авч холбогдох хяналт тавьж, АТГ-т холбогдох тайлан мэдээг гарган хүргүүлж авлигын эсрэг хууль болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэр төрийг нь сэргээх, хэлмэгдүүлэлтийн хор уршиг нийгэмд дахин бүү давтагдаасай гэдэг хүсэл тэмүүллийн дор олон нийтэд мэдээлэл түгээх, ялангуяа хүүхэд залуучуудад хэлмэгдүүлэлтийн талаар түүхийн бодит үнэнийг ойлгуулж цаашид хүний эрхийг дээдэлж, хүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулахад тодорхой хувь нэмэр оруулах иргэн болж төлөвшүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиулиудын ахлах ангийн сурагчдын дунд "Улс төрийн хэлмэгдүүлэлт-Увс аймагт" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн боловсрол соёлын газартай хамтран зохион байгуулж тэргүүлсэн сурагчдыг шагнаж урамшууллаа.

.

2016 онд аймгийн цагаатгалын салбар комисс 2 иргэний хэлмэгдэгсдийн талаарх лавлагаа авах хүсэлтийг хүлээн авч уламжлилж, нөхөн олговорыг олгууллаа.

Тав. Бусад ажил

Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, Хууль зүйн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан сүм хийдүүдийн үйл ажиллагаанд үзлэг явуулж,гэр цуглаанууд ижил урсгалын хийдүүдтэй үйл ажиллагаагаа нэгтгэхээр болж, 2сүм, 1 хийдийн зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс Монгол улсын УИХ, аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн хорооны болон техникийн багийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-ын 3 мэргэжилтэн ажиллуулж, ажлын алба сонгуулийн ажилд бүх талын дэмжлэг үзүүлснээр сонгуулийг хуулийн хүрээнд ямар нэгэн зөрчил маргаангүйгээр зохион байгууллаа.

Шинэ Үндсэн хууль батлагдсаны ойд зориулсан шатрын аймгийн аврага шалгаруулах тэмцээнийг аймгийн ИТХ-аас зохион байгуулалтаар хангаж, шатар сонирхогчдын улсын аварна шалгаруулах тэмцээнд аймгаас оролцсон эрэгтэй 1 тамирчин 9-р байранд, эмэгтэй нь 14-р байранд тус тус шалгарлаа. зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөөр 444 хүн сонгогдож бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.

Аймаг, сумын ИТХ тараагүй. Аймаг, сумын ИТХ-ын шийдвэрт Засаг дарга хориг тавиагүй.

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал, багийн ИНХ-ын үйл ажиллагааны зардлыг хурлын төсөвт тооцож тусгах, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-т аймгийн Хурлыг хариуцдаг нэгж бий болгох, шугамаар зохион байгуулагдах хурал зөвлөгөөн бусад арга хэмжээ болон Удирдлагын академи дээр аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион

байгуулах, НӨУБ-ын ажилтан, сонгуультны бүсчилсэн, семинар, уулзалт, гадаад дотоодын арга хэмжээнд ИТХ-ын төлөөллийг оролцуулах, аймаг, сумын ИТХ-ын даргын цалин, урамшуулал, бусад төрийн албаны статус, баталгааг албан ёсны баримт бичигт тусгах зэрэг асуудлыг зохих хууль, тогтоол шийдвэрүүдийг гаргуулах арга хэмжээ авахыг санал болгож байна.

Аймгийн ИТХ-аас 2017 онд дараах асуудлуудад анхаарч ажиллахыг зорилт болгож байна. Үүнд:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх нэн шаардлагатай дунд хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг ЗДТГ-тай хамтран боловсруулж батлах
2. Төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах менежмент, санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх
3. Багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчид, сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын чадавхийг сайжруулах сургалт семинарыг үе шаттай зохион байгуулах
4. Хорооны үйл ажиллагааг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх,
5. Хурлын байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
6. Аймгийн хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зардлыг нэмэгдүүлж, эрчимжүүлэх
7. Орон нутгийн татварын баазыг нэмэгдүүлэх, ОНӨ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулах
8.
9.
10.

Нарийн бичгийн дарга /Х.Дашзэвэг/

Танилцсан : Увс аймгийн ИТХ-ын дарга / Э.Насанбат /